



“ДУЛААНЫ IV ЦАХИЛГААН СТАНЦ”  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ



2021 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
**ТАЙЛАН**



# "ДУЛААНЫ IV ЦАХИЛГААН СТАНЦ"

ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

## ЭРХЭМ ЗОРИЛГО

*Эх орны хөгжлийн баталгаа  
Эрчим хүчний хүчирхэг тулгуур нь байна.*



# АГУУЛГА

## КОМПАНИЙН ТӨВЧ ТАНИЛЦУУЛГА

- Төвч танилцуулга 5
- Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын мөндчилгээ 6
- Гүйцэтгэх захирлын мөндчилгээ 7
- 2021 оны онцлох ажлууд 8
- Эрчим хүчний системд эзлэх байр суурь 9

## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

- Төлөөлөн удирдах зөвлөл 11
- Гүйцэтгэх захирлын зөвлөл 12

## ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Алба, хэлтэс, цех, нэгжүүдийн чиг үүрэг 14
- Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилготой түвшингийн биелэлт 16
- Техник эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн тухай 17
- Засварын ажлын талаар 20
- Техник, технологийн шинэчлэл, тосол 21

## САНХҮҮГИЙН ТАЙЛАН

- Аудитын санал, дүгнэлт 24
- Аудитлагдсан санхүүгийн тайлан 26
- Орлогын тайлан 27
- Өмчийн оорчлолтийн тайлан 28
- Мөнгөн гүйлгээний тайлан 29
- Санхүүгийн чадавхийн шинэжилгээ 30

## ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

- Хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар 34
- Санхүүгийн дотоод аудит 34
- MNS ISO9001:2016 Чанарын менежментийн тогтолцоо стандартын хэрэгжилт 35
- Тарифын зохицуулалт 36
- Эрчим хүчний эх үүсвэрүүдийн 2021 оны үнийн судалгаа 37

## ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАГНАЛ

- Хүний нооц 39
- Ил тод, ёс зүйн байдал 39
- Худалдан авах ажиллагааны талаар 39
- Байгаль орчныг хамгаалах чиглэлээр 40

## НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

- Нийгмийн асуудалд чиглэсэн ажлууд 42
- Хор саармагжуулах бүтээгдэхүүн түгээлт 42
- Соёл урлаг, олон нийтийн үйл ажиллагааны чиглэлээр 43



# КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



- > ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
- > ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ
- > ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ
- > 2021 ОНЫ ОНЦЛОХ АЖЛУУД
- > ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМД ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ




## КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

"ДЦС-4" ТӨХК-ийн суурийг 1979 онд тавьж, 1983 онд эхний агрегат 80 МВт, 1984 онд 2 агрегат бүхий 180 МВт, 1985 онд 3 агрегат бүхий 280 МВт, 1986 онд 4 агрегат бүхий 380 МВт, 1990 онд 5 агрегат бүхий 460 МВт, 1991 онд 6 агрегат бүхий 540 МВт-ын суурилагдсан хүчин чадалтай болсон бөгөөд өөрийн инженерүүдийн санаачлагаар хүчин чадлыг 2007 онд 20 МВт-аар нэмэгдүүлсэн. 2015 онд Турбоагрегат №7-г шинээр ашиглалтанд оруулж, 2019–2020 онд Турбоагрегат №1–4-г шинэчилсэнээр нийт 772 МВт цахилгаан эрчим хүчний, 1373 Гкал дулааны эрчим хүчний суурилагдсан хүчин чадалтай ажиллаж байна.

Тус компанийн эзэмшилд захиргааны, ахуй үйлчилгээний, лабораторийн, үйлдвэрлэлийн, засварын

зэрэг 66,7 га талбай бүхий 89 барилга, 174 байгууламж багтдаг бөгөөд төвийн бүсийн цахилгаан эрчим хүчний хэрэглээний 68,9 хувийг, Улаанбаатар хотын дулааны эрчим хүчний хэрэглээний 55 хувийг дангаараа үйлдвэрлэн хэрэглэгчдийн тав тухтай байдлыг ханган ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн Газрын 2001 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 164 дүгээр тогтоолоор Дулааны IV цахилгаан станцыг бие даасан Төрийн өмчит хувьцаат компани болгон зохион байгуулсан. Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 335 дугаар тогтоолоор Төрийн өмчийг эзэмших хувь хэмжээг шинэчлэн тогтоосон.





## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ



“ДЦС-4” ТӨХК-ийн 2021 оны үйл ажиллагааны тайланг хүргүүлж байгаа энэ мөчид компанийн нийт хамт олон, хамтран ажилласан Эрчим Хүчний Яам, Сангийн Яам, Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар, Эрчим хүчний зохицуулах хороо, МУ-ын Хөгжлийн Банк, бусад

түнш байгууллагууддаа ТУЗ-ийн нэрийн өмнөөс болон хувиасаа мэндчилгээ дэвшүүлж байна.

2021 онд “ДЦС-4” ТӨХК нь цахилгаан, дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийг тасралтгүй явуулж, горим параметрийн даалгаарыг бүх төрлөөр нь биелүүлэн ажиллалаа. Станцын хүчин чадлыг нэмэгдүүлж үр ашгийг дээшлүүлэх, найдвартай ажиллагаа, тогтвортой хөгжлийг хангах чиглэлээр “Турбоагрегат №1-4-ын шинэчлэл”-ийн төслийн хүрээнд тайлант онд 2 турбоагрегатыг шинэчлэн, төслийн ажлын бүртэн дуусгаж улсын комисст хүлээлгэн өгснөөр станцын суурилагдсан хүчин чадлыг 89 МВт-аар нэмэгдүүлсэн болно.

2021 онд “ДЦС-4” ТӨХК цахилгаан, дулааны эрчим хүчний боловсруулалт, түгээлтийн төлөвлөгөөг давуулан биелүүлж, ДХЦЭХ-ийг хэмнэж, жишмэл түлшний хувийн зарцуулалт, нэгжийн өөрийн өртгийг бууруулан 352.3 тэрбум төгрөгийн орлоготой ажиллан төлөвлөгөөг 125.5 хувиар биелүүлж зорилтот түвшин, техник эдийн засгийн үзүүлэлтүүдийг бүрэн биелүүлсэн байна.

2021 ондоо амжилтаа бататган, хэрэглэгчдээ цахилгаан, дулааны эрчим хүчээр тасралтгүй найдвартай хангаж ажиллана гэдэгт итгэл дүүрэн байна.

Сайн үйлс дэлгэрэх болтугай.

Б.Ерэн-Өлзий  
ТУЗ-ийн дарга, Эрчим хүчний яам, Бодлого төлөвлөлтийн газрын дарга





## ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

"ДЦС-4" ТӨХК-ийн Хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн Удирдах Зөвлөл, хамтран ажилладаг түнш байгууллагууд болон нийт хамт олон тэдний гэр бүл, мөн бодлого, шийдвэрээр дэмжин ажиллаж ирсэн Улсын Их Хурал, Засгийн Газар, Сангийн яам, Эрчим хүчний яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Эрчим хүчний зохицуулах хороо болон бусад байгууллага хамт олонд талархсанаа илэрхийлье.

Дэлхий нийтийг хамраад буй цар тахалын энэ үед бид хэрэглэгчиддээ цахилгаан, дулаанаар хангах эрхэм үүргээ нэр төртэй биелүүлж, эрчим хүч үйлдвэрлэлийн төлөвлөгөөг давуулан биелүүлэхийн зэрэгцээ техник, технологийн шинэчлэлийн төсөл, хөтөлбөрүүдээ амжилттай хэрэгжүүлж дуусгасан жил байлаа.

Манай хамт олон тайлант онд:

- Станцын суурилагдсан хүчин чадлыг 89 МВт-аар нэмэгдүүлэх төслийг манай хамт олны хүч хөдөлмөр, төр засгийн дэмжлэгтэйгээр бүрэн хэрэгжүүлснээр бодит үр дүнд хүрлээ.
- Бид түүхэндээ анх удаа жилд 4 тэрбум кВт.цаг цахилгаан эрчим хүчийг түгээсэн бөгөөд өмнөх онтой харьцуулахад 400 сая кВт.цаг-аар илүү буюу импортын цахилгаанд төлөх 100-аад тэрбум төгрөгийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэснээр Эрчим хүчний системийн санхүүгийн тэнцэлд зөрөг үр дүнг үзүүлээ.

- Цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн төлөвлөгөөг 110,6 хувиар биелүүлж, 4,1 тэрбум кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж, цахилгаан эрчим хүч түгээлтийн төлөвлөгөөг 111,4 хувиар биелүүлж, 410,7 сая кВтц-аар, 2020 онтой харьцуулахад 401,1 сая кВтц-аар тус тус илүү түгээсэн байна.



- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо-Шаардлага, хэрэглэх заавар ISO45001:2018 стандартын хэрэгжилтийг баталгаажуулсан гэрчилгээг гардан авлаа.
- Үнсэн сан №5-ыг сэргээж ашиглалтад оруулахад бэлтгэх ажлыг амжилттай хэрэгжүүллээ.

Монгол улсын хөгжлийн тулгуур болсон эрчим хүчний голлох үйлдвэрлэгч "ДЦС-4" ТӨХК-ий хамт олны өмнөөс нийт хэрэглэгчиддээ болон бидэнтэй хамтран ажилладаг төрийн болон дотоод, гадаадын байгууллага, хамт олон, хувь хүмүүст талархал дэвшүүлж, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Ү.Төмөрхуяг

"ДЦС" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал





## 2021 ОНЫ ОНЦЛОХ АЖЛУУД

- ★ Станцын суурилагдсан хүчин чадлыг 89 МВт-аар өргөтгөх Турбоагрегат №1-4-ыг шинэчлэх төслийг бүрэн хэрэгжүүлж, улсын комисст хүлээлгэн өглөө.
- ★ Түүхэндээ анх удаа жилд 4 тэрбум кВт.цаг цахилгаан эрчим хүчийг түгээсэн бөгөөд өмнөх онтой харьцуулахад 400 сая кВт.цаг-аар илүү бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн.
- ★ MNS ISO 45001:2018 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо стандартыг нэвтрүүлээ.
- ★ ПЗ500-180-3 насосыг сэргээн засварлаж, ажиллагаанд оруулсан.
- ★ Үнсэн сан №5-ыг хоослох төслийг хэрэгжүүлж, 1,2 сая м<sup>3</sup> үнсэн сан бэлтгэсэн.
- ★ Компани ЦЭХ, ДЭХ-ний үйлдвэр санхүүгийн төлөвлөгөөг 100% биелүүлж салбарын байгууллагуудаа тэргүүлэн ажиллалаа.
- ★ Туузан дамжуулагчуудын хоолойнуудын нүүрсний урсгал хэсгүүдийн металлын элэгдлийг бууруулах зорилгоор решетка бүхий нүүрсэн хуяг шинээр хийж байрлуулсан.
- ★ Токарийн суурь машин дээр цилиндр гадаргуу өнгөлөх зориулалттай бага оврын төхөөрөмж шинээр хийсэн.








## ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМД ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

ДЦС-уудын дотоод хэрэгцээний  
цахилгаан эрчим хүчний хувь



ДЦС-уудын жишмэл түлшний  
хувийн зарцуулалт /цахилгаанд/  
гр/квт.ц



ДЦС-уудын жишмэл түлшний  
хувийн зарцуулалт /дулаанд/  
кг/Г кал



# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



> Төлөөлөн удирдах зөвлөл  
> Гүйцэтгэх захирлын зөвлөл



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

| № | Нэр          | Албан тушаал  |
|---|--------------|---|
| 1 | Б.Ерэн-Өлзий | ТУЗ-ийн дарга, Эрчим хүчний яам, Бодлого төлөвлөлтийн газрын дарга                                      |
| 2 | Н.Мягмар     | ТУЗ-ийн гишүүн, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Хууль, эрх зүйн газрын дарга                         |
| 3 | Д.Болд       | ТУЗ-ийн гишүүн, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, референт   |
| 4 | Ё.Энхтуяа    | ТУЗ-ийн гишүүн, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газар, ахлах шинжээч                           |
| 5 | Н.Амартөвшин | ТУЗ-ийн гишүүн, Эрчим хүчний яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, шинжээч             |
| 6 | Л.Гэрэлмаа   | ТУЗ-ийн гишүүн, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Төрийн өмчийн ашиглалтын хэлтэс, мэргэжилтэн |
| 7 | Г.Атармаа    | ТУЗ-ийн хараат бус гишүүн, Өмгөөлөгч  |
| 8 | В.Бат-Эрдэнэ | ТУЗ-ийн хараат бус гишүүн, МҮОНТВ-ийн үндэсний зөвлөлийн гишүүн   |
| 9 | Р.Ганжуур    | ТУЗ-ийн хараат бус гишүүн, МЭХИХ-ны гүйцэтгэх захирал   |





## ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ЗӨВЛӨЛ



Зөвлөлийн дарга, Гүйцэтгэх захирал  
Ү.Төмөрхуяг



Зөвлөлийн гишүүн, Тэргүүн дэд  
захирал бөгөөд Ерөнхий инженер  
Б.Ганхуяг



Зөвлөлийн гишүүн,  
Бизнес үйлчилгээ эрхэлсэн  
дэд захирал Б.Сандуйжав



Зөвлөлийн гишүүн,  
Нийгмийн ажил  
эрхэлсэн дэд захирал  
Н.Мунгун



Зөвлөлийн гишүүн, Ерөнхий  
инженерийн орлогч  
Р.Ганбат



Зөвлөлийн гишүүн, Захиргаа,  
хүний нөөцийн албаны дарга  
Ш.Туухайнжин



Зөвлөлийн гишүүн,  
Хяналтын албаны дарга  
Д.Өсөхбаяр



Зөвлөлийн гишүүн, Судалгаа  
хөгжлийн албаны дарга  
Г.Галбадрах



Зөвлөлийн гишүүн, Телевэлт  
эдийн засгийн хэлтсийн дарга  
Ж.Отгон



Зөвлөлийн гишүүн, Санхүү  
бүртгэлийн хэлтсийн дарга  
Д.Төмөртоого



Зөвлөлийн гишүүн, Зуухан  
цехийн дарга Л.Ганболд



Зөвлөлийн НБ-ийн дарга,  
Захиргаа, хүний нөөцийн  
албаны Ахлах мэргэжилтэн  
Д.Амаржаргал



## ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

- > АЛБА, ХЭЛТЭС, ЦЕХ, НЭГЖҮҮДИЙН ЧИГ ҮҮРЭГ
- > ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИНГИЙН БИЕЛЭЛТ
- > ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТУХАЙ
  - > ЗАСВАРЫН АЖЛЫН ТАЛААР
  - > ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН ШИНЭЧЛЭЛ, ТӨСӨЛ





## АЛБА, ХЭЛТЭС, ЦЕХ, НЭГЖҮҮДИЙН ЧИГ ҮҮРЭГ

### Захиргаа, хүний нөөцийн алба

Компанийн хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх, хөдөлмөрийн харилцааг зохицуулах, хууль эрх зүйг мөрдүүлэн ажиллах

### Хяналтын алба

Компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөх хууль тогтоомж, стандарт, дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулах бодлого хэрэгжүүлж, гарсан зөрчлийн шалтгааныг тогтоож, залруулах арга хэмжээг төлөвлөх, гүйцэтгэлд хяналт тавих

### Үйлдвэрлэлийн алба

Цахилгаан, дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийг найдвартай, тасралтгүй явуулах бодлого хэрэгжүүлж, үйлдвэр санхүүгийн төлөвлөгөө, горим параметрийн даалгаврыг биелүүлэх, цехүүдийн өдөр тутмын ажлын уялдааг зохицуулж, ашиглалтын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах

### Засварын алба

Тонголлын засварын хэтийн бодлого боловсруулан төлөвлөгөөт их, дунд, урсгал засвар болон төлөвлөгөөт бус засварын ажлуудыг удирдан зохион байгуулж гүйцэтгүүлэх, түүний чанарт хяналт тавих

### Судалгаа хөгжлийн алба

Шинэчлэл, инновацийн чиглэлээр судалгаа хийж, техник, технологийн хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх

болон эрчим хүч хэмнэлтийн бодлого хэрэгжүүлэх, металын шинжилгээ, гагнуурын технологи боловсруулж, дүгнэлт гаргах, програм хангамжийн аюулгүй байдлыг хангах, гадаад ба дотоод цахим сүлжээ, камерын хяналтын системийг хариуцан ажиллах

### Борлуулалт, маркетингийн алба

Холбогдох хууль, дүрэм, журамд нийцүүлэн иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулан цахилгаан, дулааны эрчим хүчийг борлуулах, үндсэн бус үйл ажиллагаанаас орлого олох, борлуулалтын орлогыг бүрэн төвлөрүүлэх, өөрийн түгээлтийн шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээг хариуцан зохион байгуулах, маркетингийн үйл ажиллагаа явуулах

### Төлөвлөлт эдийн засгийн хэлтэс

Компанийн хэтийн болон жилийн бизнес төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих, санхүү эдийн засгийн үйл ажиллагаанд судалгаа шинжилгээ хийж, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх бодлого боловсруулан, санхүүгийн менежментийн удирдлагаар хангах

### Санхүү бүртгэлийн хэлтэс

Мөнгөн урсгалыг оноочтой төлөвлөх, төсвийн гүйцэтгэлд хяналт тавих, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үйл ажиллагаагаа удирдан, өмч хөрөнгөнд бүртгэлээр хяналт тавьж, байгууллагын удирдлагын шийдвэр гаргахад мэдээ, мэдээлэлээр хангах





### Худалдан авах ажиллагааны хэлтэс

Компанийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж, шаардлагатай нөөцөөр цаг хугацаанд нь хангах

### Нийгэм ахуйн хэлтэс

Компанийн тохижилт, гоо зүй, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, барилга байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээнд хяналт тавих, биеийн тамир, спорт, урлаг, олон нийтийн үйл ажиллагааг зохион байгуулах

### Түлш дамжуулах цех

Гэрээний дагуу технологийн шаардлага хангасан нүүрсээр зуухыг тасралтгүй хангах

### Зуухан цех

Түлшийг хүлээн авч боловсруулан, чанарын шаардлага хангасан технологийн уур үйлдвэрлэх, утааны хийг цэвэршүүлэх, үнс, шаарга зайлуулах

### Турбин цех

Дулаан, цахилгааны эрчим хүчийг хослон үйлдвэрлэх, станцыг техникийн усаар тасралтгүй хангах

### Цахилгаан цех

Цахилгаан энергийг үйлдвэрлэх, цахилгаан тоноглол, харилцаа холбооны найдвартай ажиллагааг хариуцан, устөрөгчийг үйлдвэрлэж, хангах

### Дулааны хянах хэмжүүр автомашины цех

Станцын дулааны процессын хэмжих хэрэгсэл, автоматжуулалт, технологийн програм хангамжийн найдвартай ажиллагааг хангах

### Хими цех

Станцын дотоод цикл, дулааны шугам сүлжээний нэмэлт ус болон үйлдвэрийн уурын тэжээлийн усыг боловсруулах, уур ус, хийн химийн горимд хяналт тавих

### Механик цех

Станцын засварын ажилд шаардлагатай металл хийц, эд анги хийх, азот, хүчилтөрөгч, шахсан агаар үйлдвэрлэж хангах, шат тавцан, өргөх зөөх механизмаар үйлчлэх

### Авто аж ахуй

Авто машин механизмын бэлэн байдлыг ханган, технологийн болон засварын ажил, хүн тээвэрт шаардлагатай тээврийн хэрэгсэлээр үйлчилгээ үзүүлэх

### Эмнэлэг

Ажилтнуудад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх

### Эрчим зоог цайны газар

Хүнсний аюулгүй байдлыг хангасан, амт чанартай, эрүүл хоол унд үйлдвэрлэж, ажилтнуудад үйлчилгээ үзүүлэх





## ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИНГИЙН БИЕЛЭЛТ

2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн үзүүлэлтийг ЭХ-ний сайдын А/09 тоот тушаалаар 2020.01.20-ны өдөр батлуулан ажилласан. ТАН-4-ийн РНД 25, 26, 27-р үеийг солих шаардлагатай

болсоноор Их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын төлөөлөгөөнд тодотгол хийж, ЭХ-ний сайдын А/196 тоот тушаалаар 2021.09.23-ны өдөр баталгаажуулж мөрдөн ажилласан.

| №  | Үзүүлэлт                                   |           | Хэмжих нэгж    | 2020 оны гүйц    | 2021 оны         |                  | Зөрүү             |              |
|----|--|-----------|----------------|------------------|------------------|------------------|-------------------|--------------|
|    |  |           |                |                  | талев            | гүйц             | тал-нөөс          | хувиар       |
| 1  | Боловсруулсан                              | ЦЭХ       | сая кВт.ц      | 4,110.3          | 4,102.5          | 4,538.7          | 436.2             | 110.6        |
|    |  | ДЭХ       | мян.Гкал       | 4,029.5          | 4,205.2          | 4,172.1          | -33.1             | 99.2         |
|    | ДХЦЭХ-ний зарцуулалт                       | хувиар    | хувь           | 11.74            | 11.80            | 11.23            | -0.57             | 95.2         |
|    |  | биетээр   | сая кВт.ц      | 482.5            | 484.3            | 509.8            | 25.5              | 105.3        |
|    | Эрчим хүч түгээлт                          | ЦЭХ       | сая кВт.ц      | 3,627.8          | 3,618.2          | 4,028.9          | 410.7             | 111.4        |
|    |  | ДЭХ       | мян.Гкал       | 4,029.5          | 4,205.2          | 4,172.1          | -33.1             | 99.2         |
| 2  | <b>Нийт орлого</b>                         |           | <b>сая төг</b> | <b>295,923.4</b> | <b>280,782.6</b> | <b>352,267.4</b> | <b>71,484.7</b>   | <b>125.5</b> |
|    | Үүнээс: Борлуулалтын орлого                |           | сая төг        | 286,660.0        | 276,699.2        | 311,498.1        | 34,798.9          | 112.6        |
|    | Үйл ажил-ны бус орлого                     |           | сая төг        | 9,263.4          | 4,083.5          | 40,769.3         | 36,685.8          | 98.4         |
| 3  | <b>Нийт зардал</b>                         |           | <b>сая төг</b> | <b>330,204.0</b> | <b>297,369.8</b> | <b>333,252.9</b> | <b>35,883.1</b>   | <b>112.1</b> |
|    | Үүнээс: Үйл ажиллагааны зардал             |           | сая төг        | 291,560.3        | 293,407.6        | 322,578.2        | 29,170.6          | 109.9        |
|    | Үйл ажил-ны бус зардал                     |           | сая төг        | 38,643.6         | 3,962.1          | 10,674.6         | 6,712.5           | 269.4        |
| 4  | Татварын өмнөх ашиг /алдагдал/             |           | сая төг        | -34,280.6        | -16,587.1        | 19,014.5         | 35,601.6          | -114.8       |
| 5  | Татварын дараах ашиг /алдагдал/            |           | сая төг        | -35,487.9        | -16,587.1        | 17,829.8         | 34,416.9          | -107.5       |
| 6  | Борлуулалтын орлогын 1 төг-т ногдох зардал |           | төг            | 0.99             | 1.06             | 0.95             | -0.11             | 89.3         |
| 7  | <b>Нийт ааллага</b>                        |           | <b>сая төг</b> | <b>17,858.8</b>  | <b>12,630.0</b>  | <b>31,804.1</b>  | <b>19,174.1</b>   | <b>251.8</b> |
|    | Үүнээс:                                    | ЭХ-ний    | сая төг        | 17,045.9         | 12,215.0         | 31,334.2         | 19,119.2          | 256.5        |
|    |  | бусад     | сая төг        | 812.9            | 415.0            | 469.9            | 54.9              | 113.2        |
| 8  | <b>Нийт өглөг</b>                          |           | <b>сая төг</b> | <b>474,136.9</b> | <b>573,946.1</b> | <b>450,418.7</b> | <b>-123,527.4</b> | <b>78.5</b>  |
|    | Үүнээс:                                    | УХӨТ      | сая төг        | 407,047.0        | 504,510.5        | 349,048.8        | -155,461.7        | 69.2         |
|    |  | БХӨТ      | сая төг        | 67,089.9         | 69,435.6         | 101,369.8        | 31,934.2          | 146.0        |
| 9  | Нийт ажиллагсад                            |           | Тоо            | 1,489            | 1,490            | 1,480            | -10               | 99.3         |
| 10 | Нийт цалингийн сан                         |           | сая төг        | 46,848.5         | 46,892.8         | 46,845.7         | -47.1             | 99.9         |
| 11 | Жишмэл түлшний хувийн зарцуулалт           | цахилгаан | гр/кВт.ц       | 278.78           | 279.60           | 270.90           | -8.71             | 96.9         |
|    |  | дулаан    | кг/Гкал        | 171.67           | 172.62           | 172.17           | -0.45             | 99.7         |
| 12 | Их засвар, ТЗБХХ, Хөрөнгө оруулалт         |           | сая төг        | 23,448.8         | 25,643.8         | 23,217.2         | -2,426.6          | 90.5         |



## ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТУХАЙ

### Цахилгаан эрчим хүчний боловсруулалт

4,538.7 сая.кВт.ц ЦЭХ боловсруулан төлөвлөгөөг 110.6 хувиар биелүүлж, төлөвлөсөнөөс 436.2 сая кВтц ЦЭХ илүү үйлдвэрлэсэн. ЦЭХ-ний боловсруулалт өмнөх оноос 428.4 сая кВтц-аар өссөн.

Дотоод хэрэгцээний ЦЭХ-ний хэмжээ 11.23% болж төлөвлөгөөнөөс 0.57 нэгж хувиар бууруулсан нь 26.0 сая кВтц ЦЭХ түгээж 1,683.8 сая төгрөгийн борлуулалтын орлого олох боломжийг бий болгосон.

### Цахилгаан эрчим хүчний түгээлт





4,028.9 сая кВт.ц Цахилгаан эрчим хүч түгээж, төлөвлөгөөг 111.4 хувиар биелүүлэн 410.7 сая кВтц ЦЭХ илүү түгээсэн. 2020 онтой харьцуулахад 401.2 сая кВтц-аар буюу 11.1%-аар өссөн.

### Дулааны эрчим хүчний түгээлт

4,172.1 мянган Гкал дулааны эрчим хүч түгээж, төлөвлөгөөг 99.2 хувиар, диспетчерийн графикийг 100 хувь биелүүлж ажилласан. 2020 онтой харьцуулахад 142.6 мянган Гкал-аар өссөн.

### Жишмэл түлшний хувийн зарцуулалт

Жишмэл түлшний хувийн зарцуулалт цахилгаанд 270.90 гр/кВт.ц, дулаанд 172.17 кг/Гкал байгаа нь төлөвлөгөөтэй харьцуулахад цахилгаанд 8.71 гр/кВт.ц-аар, дулаанд 0.45 кг/Гкал-аар тус тус буурсан байна. Өмнөх оны мөн үеэс цахилгаанд 7.88 гр/кВт.ц-аар буурч, дулаанд 0.50 кг/Гкал-аар өссөн байна.





### Нийт орлого

Нийт **352.3** тэрбум төгрөгийн орлоготой ажиллан төлөвлөгөөг **125.5** хувиар биелүүлж, орлого төлөвлөсөнөөс **71.5** тэрбум төгрөгөөр өссөн. Цахилгаан эрчим хүчний борлуулалтын орлого төлөвлөсөнөөс **35.4** тэрбум төгрөгөөр өсөж, дулааны эрчим хүчний борлуулалтын орлого **0.6** тэрбум төгрөгөөр буурсан. 2021 оны нийт орлогын өсөлтийн **34.8** тэрбум төгрөг нь цэвэр борлуулалтын орлого, **36.8** тэрбум төгрөг /ханшийн бодит бус орлого **36.5** тэрбум төгрөг/ нь үйл ажиллагааны бус орлого байна. Нийт орлогыг 2020 онтой харьцуулахад **56.4** тэрбум төгрөг буюу **19.1%**-аар өссөн.



### Нийт зардал


Нийт **333.3** тэрбум төгрөгийн зардалтай ажиллаж, төлөвлөгөөнөөс **35.9** тэрбум төгрөгөөр өссөн. Үйл ажиллагааны зардал **29.2** тэрбум төгрөгөөр, үйл ажиллагааны бус зардал **6.7** тэрбум төгрөгөөр тус тус хэтэрсэн. Цахилгаан эрчим хүчний түгээлтийн өсөлтөөс шалтгаалан түлшний зардал **12.2** тэрбум төгрөгөөр, ашиглалтын цахилгааны зардал **4.7** тэрбум төгрөгөөр өссөн. Нийт зардлын төлөвлөгөөг **6.4** хувиар хасаж баталсан нь зардал хэтэрэхэд нөлөөлсөн.

Үйл ажиллагааны бус зардлын хэтрэлтэд валютын ханшийн бодит бус алдагдал **4.0** тэрбум төгрөг болсон нь нөлөөлсөн.



### Зардлын бүтэц

Нийт зардлын **46.6%**-ийг түлшний зардал, **19%**-ийг үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэлийн зардал, **14.1%**-ийг цалин, **2.1%**-ийг ЭМД, НДШ-ийн зардал, **4.2%**-ийг ашиглалтын цахилгаан, дулаан, усны зардал, **4.3%**-ийг урт хугацаат эзэлийн хүүгийн зардал, **1.3%**-ийг ажиллагсдын нийгмийн зардал, **1.1%**-ийг татвар, төлбөр, хураамжийн зардал, **4.1%**-ийг бусад зардал, **3.2%**-ийг үйл ажиллагааны бус бусад зардал эзэлж байна.



### Ашигт ажиллагаа

Балансын дүнгээр **17.8** тэрбум төгрөгийн ашигтай ажилласан. Валютын ханшийн бодит бус ашигийг тооцохгүйгээр **14.6** тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж, төлөвлөлөгөөт алдагдлыг **2.0** тэрбум төгрөгөөр бууруулсан.

ЦЭХ-ний нэгжийн өөрийн өртөг **52.33** төг/кВт.ц байгаа ба 1 кВт.ц ЦЭХ-ийг дунджаар 64.88 төгрөгөөр борлуулж, нэгжээс **12.55** төгрөгийн, нийт ЦЭХ-ний үйлдвэрлэлтээс **50,561.4** сая төгрөгийн ашигтай ажилласан.

ДЭХ-ний нэгжийн өөрийн өртөг **26,780.70** төг/Гкал байгаа ба 1 Гкал ДЭХ-ийг дунджаар **12,005.90** төгрөгөөр борлуулсан нь нэгжээс **14,774.81** төгрөгийн, нийт ДЭХ үйлдвэрлэлтээс **61,641.6** сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.



### Орон тоо, цалингийн сан

Компани 2021 онд **1490** хүний орон тоотой ажилласнаас дансны дундажаар **1480** ажиллагсадтай ажилласан. Үүнд: Удирдлага **5**, инженер, техникийн ажилтан **299**, ажилчид **1176** байна.

Нийт цалингийн санд **46,845.7** сая төгрөг зарцуулан төлөвлөгөөнөөс **47.1** сая төгрөгөөр хэмнэсэн.

### Дундаж цалин



### Борлуулалтын орлогын нэг төгрөгт ноогдох зардал

Борлуулалтын орлогын нэг төгрөгт ноогдох зардал **0.95** болж төлөвлөсөнөөс **0.11** төгрөгөөр буурсан.

### Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалт


Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтын ажилд **25,643.8** сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс **23,217.2** сая төгрөг зарцуулж **2,426.7** сая төгрөгөөр хэмнэгдсэн. Төлөвлөгөөт ажлуудыг хийж гүйцэтгэснээр өвлийн их ачааллыг амжилттай давсан. Үндсэн тоноглолын их засварт **13.3** тэрбум төгрөг зарцуулж **2.2** тэрбум төгрөгөөр хэмнэгдсэн. Туслах тоноглолд **173** тоноглолын **5.8** тэрбум төгрөгийн засварын ажил төлөвлөж **5.6** тэрбум төгрөг зарцуулж **0.2** тэрбум төгрөг хэмнэгдлээ. Барилгын их засварын **11** ажилд **1.0** тэрбум төгрөг төлөвлөж **1.0** зарцуулсан.

ТЗБАХ-ний **8** ажилд **314.5** сая төгрөг төлөвлөж **195.8** сая төгрөг зарцуулж **118.7** сая төгрөг хэмнэсэн, Зуух№5,6-д лед гэрэл суурилуулах ажил, цахилгаан хөдөлгүүрүүдэд тоолуур суурилуулах ажил он дамжин хийгдэхээр болсон.

Хөрөнгө оруулалтын **34** ажилд **2,933.2** төлөвлөж **3,110.6** сая төгрөг зарцуулсан. Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд Оптик микроскоп болон Азот үйлдвэрлэх тоноглолууд он дамжин нийлүүлэгдсэн.




Авлага



2021 онд **31.8** тэрбум төгрөг болж оны эхнээс **13.9** тэрбум төгрөгөөр өссөн. НХАЗ-ын авлага **31.5** тэрбум төгрөг болж оны эхнээс **14.8** тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн. УБДС-ээс авах авлагыг **574.8** сая төгрөгөөр, бусад авлагыг **342.9** сая төгрөгөөр бууруулж ажилласан.

Өр төлбөр



Нийт өр төлбөр **450.4** тэрбум төгрөг болж оны эхнээс **23.7** тэрбум төгрөгөөр буурсан нь ТА7-ийн бүртгэлийг өөрчилж урьдчилж олсон орлогыг бууруулсан болон валютын ханшийн өөрчлөлттэй холбоотой, БХӨТ **101.4** тэрбум төгрөг болж оны эхнээс **34.3** тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Урт хугацаат эзэлийн тухайн жилд төлөх төлбөр **43.8** тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн. Татварын өглөг болон бэлтгэн нийлүүлэгчдийн өглегийг **14.3** тэрбум төгрөгөөр бууруулсан.

## ЗАСВАРЫН АЖЛЫН ТАЛААР

2021 онд станцын дүнгээр:

| Засварын төрөл                  | Төлөвлөгөө /саяТ/ | Гүйцэтгэл /саяТ/ |
|---------------------------------|-------------------|------------------|
| Үндсэн тоноглолын засвар        | 15,552.1          | 13,303.1         |
| Туслах тоноглолын их засвар     | 5,830.0           | 4,720.2          |
| Туслах тоноглолын урсгал засвар | 3,968.0           | 3,064.1          |
| Дүн                             | 25,350.1          | 21,087.4         |

Гэрээгээр хийгдсэн ажил:

2021 онд тоног төхөөрөмжийн их, урсгал засварын ажил гүйцэтгүүлэхээр нийт **22** гэрээт ажилд хяналт тавьж ажилласан.

| Он       | Үндсэн тоноглол | Туслах тоноглол | Дүн |
|----------|-----------------|-----------------|-----|
| 2019 онд | 5               | 21              | 26  |
| 2020 онд | 6               | 14              | 20  |
| 2021 онд | 7               | 15              | 22  |

Үндсэн тоноглолын графикт засвар

2021 онд төлөвлөгөөт 4 тоноглолд их засвар, 2 тоноглолд дунд засвар хийхээр төлөвлөгдсөн. Үүнд: Үндсэн тоноглолын ТАН#4, 7-н их засвар Блокуудын хамт, Зуух №1, 5 их засвар, Зуух №3, 7-н дунд засвар хийгдэхээр төлөвлөгдөн ондоо багтаан 100% гүйцэтгэсэн.

Туслах тоноглолын их засвар

2021 онд тодотголоор 173 тоноглолд их засвар хийхээр төлөвлөгдсөн. Хасагдсан 3 тоноглол. Засварын ажлын биелэлт 100%.

Засвар бэлтгэлийн хэсгийн үйл ажиллагааны талаар:

Энэ онд тус хэсэгт цех нэгж, компаниуд өндөр, нам, дунд даралтын **361** ш хаалт хүлээлгэн өгсөн.

Уг хаалтуудыг ангилан ялгалт хийж сэргээн засварлаж болох **288** ширхэг хаалтыг бүрэн сэргээн засварласан. /Эдгээр хаалтны зах зээлийн үнэ нь нийт мөнгөн дүнгээр **566,7** саяТ болж байна/.

Нийт сэргээн засварласан хаалтны **288** ш хаалтны **287** ш буюу **99%** нь өндөр даралтын, **1** ш буюу **0.4%** нь нам даралтын хаалт байв.

Энэ онд Зуух №3, 7-н дунд засвар, Зуух №1, 5-н их засвараар Ду65-н вентиль нийт **70** ш-г, Ду20-н вентиль **171** ш-г засварынх нь хугацаанд сэргээн засварлаж хүлээлгэн өгсөн. 2021 онд засварт хэрэглэсэн нийт винтелийн **49,4%**-г засвар бэлтгэлийн хэсэг нь сэргээн засварласан байна.

## ТЕХНИК ТЕХНОЛОГИЙН ШИНЭЧЛЭЛ, ТӨСӨЛ



АНУ-ын Мянганы Сорилын Сангийн санхүүжилтээр хэрэгжих онд Ус дахин боловсруулах үйлдвэрээс гарах усыг станцын техникийн усанд ашиглах төслийн зөвлөх шалгаруулах олон улсын нээлттэй тендер зарлаж, зөвлөхөөр Герман улсын "FICHTNER" түүний хамтрагч Монгол улсын "ИКОН Консалтинг" ХХК шалгарсан.

Зөвлөхүүд 2021 оны 08-р сарын 26-наас ажлаа эхлүүлсэн. "ИКОН Консалтинг" ХХК-ийн туслан гүйцэтгэгч

### "ХАЯГДАЛ УС ДАХИН БОЛОВСРУУЛАХ" ТӨСӨЛ

болох геодезийн үйлчилгээ үзүүлэх "Галгэр" ХХК-ийн мэргэжилтэнүүд ХУДБҮ-ээс ирэх усны шугамын трасс дагуух хэмжилт, газар доорх биетийн илрүүлэлт хийж, дээсгэр зургуудыг станцын хашааны гадна болон дотор талд гаргасан.

Монголын МСС-аас 2021 оны 02 дугаар сард "Ус дамжуулах шугам хоолой, холбогдох дэд бүтэц, "ДЦС-3", "ДЦС-4" ТӨХК-ийн усны схемийн зураг төсөл боловсруулах төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ болон Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх, ус дамжуулах шугам хоолойн трассын дагуу Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө боловсруулах зөвлөхийн үйлчилгээ"–ний тухай олон улсын тендер зарлаж гүйцэтгэгч шалгаруулсан. ХУДБҮ-ээс станц хүрэх үндсэн трасс болон станцын хашаан доторх трассын дагуу байгаль орчин, амьтан ургамалд хэрхэн нөлөөлөх, нөлөөллийг гүйцэтгэгч "Экотрөйд" ХХК, "Soil Trade" ХХК-ууд тодорхойлсон.

### ҮНСЭН САН №5

Өсөн нэмэгдэж буй цахилгаан, дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийг даган хаягдал үнсийг хадгалах нэмж үнсэн сан барих газаргүй болж байна. Иймд хуучин үнсэн санд хадгалагдаж буй үнсийг ухаж, хуурай үнс хадгалах сан руу тээвэрлэх шинэ технологийг нэвтрүүлсэн. Тайлант онд хуучин Үнсэн санд №5-ыг хадгалагдаж байсан **501.199,9** м<sup>3</sup> эзэлхүүнтэй үнсийг ухаж хоосолсон. Үнсэн сан №5-ын далан тойрсон үнсний хаягчийн 1200 м коллекторыг Ф425 мм-ын шугамаар 106 ш бетон дэрэн дээр монтажлаж, Ф325 мм-ын шугамаар хаягч шугам тулгуурын хамт суурилуулсан. Машин механизм явсан даланг сэргээн засварлаж ашиглалтад оруулсан.





## “ТА№1-4-ИЙГ ШИНЭЧЛЭХ” ТӨСӨЛ

2021 оны 12-р сарын 14-нд «Турбоагрегат №1-4-г шинэчлэх төсөл» амжилттай өндөрлөж, ЭХ-ний сайдын тушаалаар байгуулагдсан ЭХЯ-ны Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Батзоригоор ахлуулсан 24 хүний бүрэлдэхүүнтэй улсын комиссын гишүүдийн 100 хувийн саналаар байнгын ашиглалтанд хүлээн авлаа.

Энэ төслийн үр дүнд станцын суурилагдсан хүчин чадал цахилгаанаар 89 МВт-р, дулаанаар 74 Гкал-р нэмэгдэж, найдвартай ажиллах хугацаа 220,000

цагаар нэмэгдэж, жилд 200,000 тн гаруй бодит нүүрсний хэмнэлт гарах юм.

Төслийг Монгол Улсын Хөгжлийн Банк дотоодын эх үүсвэрээр санхүүжүүлж, ОХУ-ын Уралын Турбины Завод ерөнхий гүйцэтгэгчээр ажиллалаа. Дэлхий нийтийг хамарсан цар тахалын амаргүй нөхцөлд станцын хамт олон, ОХУ-ын мэргэжил нэгт нөхөдтэй хамтран, энэхүү өндөр ач холбогдол бүхий чухал төслийг амжилттай хэрэгжүүлж чадлаа.





## САНХҮҮГИЙН ТАЙЛАН

- > АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН
  - > ОРЛОГЫН ТАЙЛАН
  - > ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
  - > МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
- > 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ЧАДАВХИЙН ШИНЖИЛГЭЭ





## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



### ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Баян найруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-47-30  
E-mail: info@audit.gov.mn

2022.03.15 № 041602

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ДУЛААНЫ IV ЦАХИЛГААН СТАНЦ  
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Ү.ТӨМӨРХУЯГ ТАНАА

#### Хараат бус аудиторын тайлан

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч компаниас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон зүйл


Дулааны IV цахилгаан станц ТӨХК нь Хөгжлийн Турбоагрегат 1,2,3,4-ийн шинэчлэлтэй холбоотойгоор 76.6 сая евро буюу 234,605.5 сая төгрөгийн зээл авсан байна. Урт хугацаат зээлийн эргэн төлөлт 11.4 сая евро буюу 30,180.4 сая төгрөг, зээлийн үлдэгдэл 75.1 сая евро буюу 241,907.9 сая төгрөг байна. 2021 онд төлөгдөх үндсэн зээл болон хүүгийн төлбөрөөс хугацаандаа төлөгдөөгүй үндсэн зээлийн төлбөр 7.3 сая евро буюу 23,502.1 сая төгрөг, хүүгийн төлбөр 1.7 сая евро буюу 5,540.6 сая төгрөг байна.

Хөгжлийн банкны зээлийн эргэн төлөлттэй холбоотойгоор Эрчим Хүчний Зохицуулах Хорооноос 2022 оны сүүлийн хагас жилд үнэ тарифт өөрчлөлт оруулж, зээлийн төлбөр төлөх эх үүсвэрийг шийдвэрлэхээр төлөвлөн ажиллаж байна.

#### Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

\\10.10.12.208\ltd\_khaleg\yaman\_bokoy\2022\0315\_Audit\2\_Gazpr - 83.Docx





## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Эрчим хүчний сайдын 2021 оны 9 дүгээр тушаалаар 2021 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт орлогыг 280,782.7 сая төгрөгөөр, нийт зардлыг 297,369.8 сая төгрөгөөр, алдагдлыг 16,587.1 сая төгрөг байхаар баталсан байна. Эрчим хүчний сайдын 2021 оны 196 дугаар тушаалаар их зэвсэр, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 935.0 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 348,222.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 329,207.7 сая төгрөгийн зардал гарган, 17,829.8 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

**Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 7 арга хэмжээ төлөвлөж, гүйцэтгэл 93 хувьтай гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

*В.М.* ЦЭЦЭРЭНЧИМЭГ



## АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

/Мянган төгрөг/

|  | 2020 оны 12 сарын 31   | 2021 оны 12 сарын 31   |
|--|------------------------|------------------------|
| <b>Хөрөнгө</b>                             |                        |                        |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө            | 2,778,942.3            | 9,045,731.2            |
| Дансны авлага                              | 17,858,805.1           | 31,804,115.5           |
| Бараа материал                             | 19,990,657.2           | 19,376,776.8           |
| Урьдчилж төлсөн зардал/ тооцоо             | 4,905,175.4            | 1,649,758.3            |
| Үндсэн хөрөнгө                             | 895,473,181.5          | 912,358,875.8          |
| Биет бус хөрөнгө                           | 76,973,695.3           | 76,925,722.2           |
| Бусад эргэлтийн бус хөрөнгө                | 40,075,045.2           | 105,136.9              |
| <b>Нийт хөрөнгө</b>                        | <b>1,058,055,502.0</b> | <b>1,051,266,116.7</b> |
| <b>Өр төлбөр</b>                           |                        |                        |
| Дансны өглөг                               | 10,474,997.1           | 8,650,577.6            |
| Цалингийн өглөг                            | 5,623,480.6            | 5,964,378.7            |
| Татвар, НДШ-ийн өр                         | 7,469,629.4            | 2,300,387.4            |
| УХ-т эзэлийн тайлант үеийн өглөг           | 34,626,216.9           | 74,597,989.8           |
| Хүүгийн өглөг                              | 3,228,876.3            | 7,080,411.9            |
| Нөөц өр төлбөр /БХ-т/                      | 1,968,227.8            | 1,606,419.9            |
| Урьдчилж орсон орлого                      | 5,098,331.8            | 942,139.4              |
| Бусад богино хугацаат өр                   | 3,698,433.8            | 1,169,675.9            |
| Урт хугацаат зээл                          | 385,163,163.7          | 325,797,067.3          |
| Нөөц өр төлбөр /УХ-т/                      | 8,520,087.8            | 9,318,690.9            |
| Хойшлогдсон татварын өр                    | 13,363,759.9           | 13,933,080.2           |
| Хойшлогдсон орлого                         | 111,160,337.3          | 18,877,481.3           |
| <b>Нийт өр төлбөр</b>                      | <b>590,395,542.4</b>   | <b>470,238,300.6</b>   |
| <b>Эзэмшигчийн өмч</b>                     |                        |                        |
| Төрийн өмч                                 | 107,919,748.9          | 227,071,740.0          |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл        | 312,961,105.4          | 311,515,695.2          |
| Эздийн өмчийн бусад хэсэг                  | 78,008,219.9           | 78,008,219.9           |
| Хуримтлагдсан ашиг / алдагдал/             | -31,229,114.6          | -35,567,839.1          |
| <b>Эздийн өмчийн дүн</b>                   | <b>467,659,959.6</b>   | <b>581,027,816.1</b>   |
| <b>Нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b> | <b>1,058,055,502.0</b> | <b>1,051,266,116.7</b> |

## ОРЛОГЫН ТАЙЛАН

/Монгол төгрөг/

| №  | Үзүүлэлт  | 2020.12.31           | 2021.12.31           |
|----|---|----------------------|----------------------|
| 1  | <b>Борлуулалтын орлого /цэвэр/</b>                        | <b>286,659,965.0</b> | <b>311,499,629.9</b> |
| 2  | Борлуулалтын өртөг  | 285,822,703.2        | 313,256,103.4        |
| 3  | <b>Нийт ашиг /алдагдал/</b>                               | <b>837,261.8</b>     | <b>-1,756,473.5</b>  |
| 4  | Түрээсийн орлого  | 173,463.7            | 180,717.4            |
| 5  | Хүүний орлого   | 111,345.7            | 2,733.6              |
| 6  | Ногдол ашгийн орлого                                      |                      |                      |
| 7  | Эрхийн шимтгэлийн орлого                                  |                      |                      |
| 8  | Бусад орлого  | 8,621,000.6          | 4,117,760.9          |
| 9  | Борлуулалт, маркетингийн зардал                           | 2,607,454.5          | 2,140,421.9          |
| 10 | Ерөнхий удирдлагын зардал                                 | 3,121,752.4          | 4,827,102.8          |
| 11 | Санхүүгийн зардал   |                      |                      |
| 12 | Бусад зардал  | 2,426,033.0          | 4,485,336.6          |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз /гарз/                | -35,878,706.1        | 32,415,627.4         |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассан олз /гарз/                 | 10,272.7             | 4,493,011.9          |
| 15 | Биет бус хөрөнгө данснаас хассаны олз /гарз/              |                      |                      |
| 16 | Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз /гарз/           |                      |                      |
| 17 | Бусад ашиг /алдагдал/                                     |                      |                      |
| 18 | <b>Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/</b>              | <b>-34,280,601.4</b> | <b>19,014,492.5</b>  |
| 19 | Орлогын татварын зардал                                   | 1,207,284.1          | 1,184,714.1          |
| 20 | <b>Татварын дараах ашиг /алдагдал/</b>                    | <b>-35,487,885.5</b> | <b>17,829,778.4</b>  |
| 21 | Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг /алдагдал/ |                      |                      |
| 22 | <b>Тайланг үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>                | <b>-35,487,885.5</b> | <b>17,829,778.4</b>  |
| 23 | Бусад дэлгэрэнгүй орлого                                  |                      |                      |
|    | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү               |                      |                      |
|    | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү                        |                      |                      |
|    | Бусад олз /гарз/  |                      |                      |
| 24 | <b>Орлогын нийт дүн</b>                                   |                      |                      |
| 25 | <b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг /алдагдал/</b>        |                      |                      |



## ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/Мянган төгрөг/

| №  | Үзүүлэлт   | Өмч           | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн      |
|----|--|---------------|-------------------------------------|---------------------------|--------------------|---------------|
| 1  | 2019 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл                                   | 107,919,748.9 | 312,961,118.4                       | 48,769,166.9              | 6,776,980.8        | 476,427,015.1 |
| 2  | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга |               |                                     |                           | -2,430,201.5       | -2,430,201.5  |
| 3  | Залруулсан үлдэгдэл  |               |                                     |                           |                    |               |
| 4  | Тайлант үеийн цэвэр ашиг   |               |                                     |                           | -35,487,885.6      | -35,487,885.6 |
| 5  | Бусад дэлгэрэнгүй орлого   |               |                                     |                           |                    |               |
| 6  | Өмчид гарсан өөрчлөлт  |               |                                     |                           |                    |               |
| 7  | Зарласан ногдол ашиг   |               |                                     |                           | -88,008.3          | -88,008.3     |
| 8  | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн                              |               | -12,9                               | 29,239,053.0              |                    | 29,239,040.0  |
| 9  | 2020 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл                                   | 107,919,748.9 | 312,961,105.4                       | 78,008,219.9              | -31,229,114.6      | 476,659,959.7 |
| 10 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга |               |                                     |                           | -22,168,502.9      | -22,168,502.9 |
| 11 | Залруулсан үлдэгдэл  |               |                                     |                           |                    |               |
| 12 | Тайлант үеийн цэвэр ашиг   |               |                                     |                           | 17,829,778.4       | 17,829,778.4  |
| 13 | Бусад дэлгэрэнгүй орлого   |               |                                     |                           |                    |               |
| 14 | Өмчид гарсан өөрчлөлт  | 119,151,991.1 |                                     |                           |                    | 119,151,991.1 |
| 15 | Зарласан ногдол ашиг   |               |                                     |                           |                    |               |
| 16 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн                              |               |                                     |                           |                    | 29,239,040.0  |
| 17 | 2021 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл                                   | 227,071,740.0 | 311,515,695.2                       | 78,008,219.9              | -35,567,839.1      | 581,027,816.1 |



## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Мянган төгрөг/

| №   | Үзүүлэлт   | 2020 оны 12 сарын 31 | 2021 оны 12 сарын 31 |
|---|--|----------------------|----------------------|
| <b>1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>             |  |                      |                      |
| 1.1   | Мөнгөн орлогын дүн /н/   | 276,267,138.0        | 284,408,100.4        |
|   | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого                   | 270,650,498.3        | 277,827,302.0        |
|   | Бусад мөнгөн орлого  | 5,616,639.7          | 6,580,798.4          |
| 1.2   | Мөнгөн зарлагын дүн /-/  | 255,349,594.2        | 270,804,336.3        |
|   | Ажиллагчдад төлсөн   | 39,268,229.5         | 37,346,046.2         |
|   | НД-ийн байгууллагад төлсөн                                     | 10,465,000.0         | 13,113,865.8         |
|   | Бараа материал худалдан авахад төлсөн                          | 118,296,717.2        | 131,115,200.0        |
|   | Түлш шатахуун, тээврийн хөлс, салбог хэргэсэл төлсөн           | 41,895,017.8         | 34,900,738.6         |
|   | Хүүний төлбөр төлсөн   | 8,276,881.9          | 6,779,096.6          |
|   | Татварын байгууллагад төлсөн                                   | 21,446,112.3         | 20,278,275.6         |
|   | Даатгалын төлбөрт төлсөн                                       | 77,600.1             | 78,798.0             |
|   | Бусад мөнгөн зарлага   | 15,624,035.4         | 26,992,315.4         |
| 1.3   | Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн             | 20,917,543.9         | 13,603,764.1         |
| <b>2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b> |  |                      |                      |
| 2.1   | Мөнгөн орлогын дүн /н/   | 111,345.7            | 2,733.6              |
|   | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого                               |                      |                      |
|   | Хүлээн авсан хүүгийн орлого                                    | 111,345.7            | 2,733.6              |
|   | Хүлээн авсан ногдол ашиг                                       |                      |                      |
| 2.2   | Мөнгөн зарлагын дүн /-/  | 60,716,733.5         | 26,741,573.6         |
|   | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн                            | 8,931,929.2          | 4,440,112.4          |
|   | Бусад урт хугацаат хөрөнгө олж болгоход төлсөн                 | 51,784,804.3         | 21,301,461.1         |
| 2.3   | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | -60,605,387.8        | -25,738,839.9        |
| <b>3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>         |  |                      |                      |
| 3.1   | Мөнгөн орлогын дүн /н/   | 56,784,804.3         | 28,300,157.0         |
|   | Эзэл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан            | 56,784,804.3         | 28,300,157.0         |
|   | Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан   |                      |                      |
| 3.2   | Мөнгөн зарлагын дүн /-/  | 14,910,474.2         | 10,098,292.3         |
|   | Эзэл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн                         | 14,910,474.2         | 10,098,292.3         |
|   | Төлсөн ногдол ашиг   |                      |                      |
| 3.3   | Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн         | 41,874,330.1         | 41,874,330.1         |
| 4   | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ                                       | 2,186,486.4          | 6,286,788.9          |
| 5   | Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн зөний үлдэгдэл             | 592,455.9            | 2,778,942.3          |
| 6   | Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл            | 2,778,942.3          | 9,045,731.2          |



## САНХҮҮГИЙН ЧАДАВХИЙН ШИНЖИЛГЭЭ

### 1. Төлбөрийн чадварын шинжилгээ

|     | Үзүүлэлтүүд   | Харьцаа                              | 2020.12.31 | 2021.12.31 | Өмнөх оныг харьцуулахад |
|-----|---|--------------------------------------|------------|------------|-------------------------|
| 1.1 | Цэвэр эргэлтийн хөрөнгө                                   | Нийт ЗХ – БХӨТ                       | -26,654.40 | -40,435.50 | -13,781.00              |
| 1.2 | Үнэмлэхүй хөрөх хөрөнгийн харьцаа                         | МХ+ТБҮЦ / БХӨТ                       | 0.04       | 0.09       | 0.05                    |
| 1.3 | Түргэн хөрөх хөрөнгийн харьцаа                            | МХ+ТБҮЦ+Авлага / БХӨТ                | 0.29       | 0.40       | 0.11                    |
| 1.4 | Эргэлтийн харьцаа   | Нийт ЗХ / БХӨТ                       | 0.63       | 0.60       | -0.03                   |
| 1.5 | Эргэлтийн хөрөнгийн хувийн жин                            | Нийт ЗХ / Балансын цэвэр дүн         | 0.04       | 0.06       | 0.02                    |
| 1.6 | Цэвэр эргэлтийн хөрөнгийн хувийн жин                      | Цэвэр ЗХ / Нийт ЗХ                   | -0.59      | -0.65      | -0.07                   |
| 1.7 | Он дамжсан болон хугацаа хэтэрсэн ер төлбөрийн хувийн жин | Хугацаа хэтэрсэн ӨТ / Нийт ер төлбөр | 0.02       | 0.02       | 0.00                    |

### 2. Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ

|      | Үзүүлэлтүүд                                      | Харьцаа  | 2020.12.31 | 2021.12.31 | Өмнөх оныг харьцуулахад |
|------|--|--|------------|------------|-------------------------|
| 2.1  | Бие даах чадварын коэффициент                    | Өөрийн капитал / Балансын цэвэр дүн                        | 0.44       | 0.55       | 0.11                    |
| 2.2  | Санхүүгийн хамаарлын коэффициент                 | Балансын цэвэр дүн / өөрийн капитал                        | 2.26       | 1.81       | -0.45                   |
| 2.3  | Зохицуулалтын коэффициент                        | Өөрийн эргэлтийн капитал / өөрийн капитал                  | -0.06      | -0.07      | -0.01                   |
| 2.4  | Гадны капиталын хувийн жин                       | Гадны капитал / Нийт капитал (Балансын пассивын дүн)       | 0.49       | 0.35       | -0.14                   |
| 2.5  | Урт хугацаат зээл болон өөрийн капиталын харьцаа | урт хугацаат зээл / өөрийн капитал                         | 1.11       | 0.63       | -0.47                   |
| 2.6  | Гадны ба өөрийн капиталын харьцаа                | Гадны капитал / өөрийн капитал                             | 1.26       | 0.81       | -0.45                   |
| 2.7  | <b>Төлбөрийн хэлийн боломжийн үзүүлэлтүүд</b>    |  |            |            |                         |
| 2.7a | Хүү төлөх чадвар                                 | Хүү + ТӨЦА / Хүүгийн зардал                                | -2.77      | 2.31       | 4.99                    |
| 2.7b | Хүү ба үндсэн өрийг төлөх чадвар                 | Хүү + ТӨЦА + байгуулсан ҮХЗХШ / Хүүгийн зардал + Үндсэн өр | 0.07       | 0.20       | 0.15                    |
| 2.7c | Альтманы индекс                                  | 3.3k1 + 1.0k2 + 0.6k3 + 1.4k4 + 1.2k5                      | 0.66       | 1.33       | 0.67                    |
|      | K1   | хүү + ТӨЦА / Нийт хөрөнгө                                  | -0.02      | 0.03       | 0.06                    |
|      | K2   | Борлуулалтын орлого / Нийт хөр                             | 0.27       | 0.30       | 0.03                    |
|      | K3   | Өөрийн кап / Гадны капитал                                 | 0.90       | 1.58       | 0.68                    |
|      | K4   | Ногдол ашиг төлсний дараахь цэвэр ашиг / нийт хөрөнгө      | -0.03      | 0.02       | 0.05                    |
|      | K5   | Өөрийн эргэлтийн капитал / Нийт хөрөнгө                    | -0.03      | -0.04      | -0.01                   |

**3. Эргэцийн шинжилгээ**

|      | Үзүүлэлтүүд                      | Харьцаа   | 2020.12.31 | 2021.12.31 | Өмнөх онтой харьцуулахад |
|------|----------------------------------|---|------------|------------|--------------------------|
| 3.1  | Авлагын эргэц (удаа)             | Бор.ор / Авлагын дундаж үлдэгдэл                            | 15.71      | 12.54      | -3.17                    |
| 3.2  | Авлагын эргэц (өдөр)             | 360 хоног / Авлагын эргэц (удаа)                            | 22.91      | 28.70      | 5.79                     |
| 3.3  | Нөөцийн эргэц (удаа)             | ББӨ / БМУБЗ дундаж өртөг                                    | 14.65      | 15.91      | 1.27                     |
| 3.4  | Нөөцийн эргэц (өдөр)             | 360 хоног / Нөөцийн эргэц (удаа)                            | 24.57      | 22.62      | -1.96                    |
| 3.5  | Эргэлтийн хөрөнгийн эргэц (удаа) | Бор орлого / ЭХ дундаж үлдэгдэл                             | 6.69       | 5.80       | -0.89                    |
| 3.6  | Эргэлтийн хөрөнгийн эргэц (өдөр) | 360 хоног / ЭХ-н эргэц (удаа)                               | 53.83      | 62.07      | 8.24                     |
| 3.7  | Нийт хөрөнгийн ачаалал           | Бор.ор / Бал.цэвэр дүн                                      | 0.27       | 0.30       | 0.03                     |
| 3.8  | Өглөлийн эргэц (удаа)            | Зол.Худ.ав / Өг.дундаж үлдэгдэл                             | 1.16       | 1.17       | 0.01                     |
| 3.9  | Өглөлийн эргэц (өдөр)            | 360 хоног / Өглөлийн эргэц (удаа)                           | 309.50     | 307.00     | -2.50                    |
| 3.10 | Үйлдвэрлэлийн циклийн хугацаа    | Ав.эргэц (өдөр) + Нөөцийн эргэц (өдөр)                      | 47.48      | 51.32      | 3.83                     |
| 3.11 | Санхүүгийн циклийн хугацаа       | Ав.эргэц (өдөр) + Нөөцийн эргэц (өдөр) - Өглөг эргэц (өдөр) | -262.01    | -255.68    | -6.33                    |

**4. Бүтээмжийн шинжилгээ**

|     | Үзүүлэлтүүд                                   | Харьцаа  | 2020.12.31 | 2021.12.31 | Өмнөх онтой харьцуулахад |
|-----|---|--|------------|------------|--------------------------|
| 4.1 | Хөдөлмөрийн бүтээмж                           | Бор.ор / Аж.дүн дансны дундаж тоо                | 192.52     | 209.62     | 16.72                    |
| 4.2 | Үндсэн хөрөнгийн ачаалал                      | Бор.ор / Үнд.хөр.дундаж өртөг                    | 0.31       | 0.70       | 0.39                     |
| 4.3 | Материал өгөөж                                | Бор.ор / БМУБЗ дундаж өртөг                      | 14.56      | 33.20      | 18.64                    |
| 4.4 | Эдийн засгийн тогтвортой өсөлтийн коэффициент | Цэвэр ашиг - Төлсөн ногдол ашиг / Өөрийн капитал | -0.08      | 0.03       | 0.11                     |

**5. Үндсэн хөрөнгийн шинжилгээ**

|     | Үзүүлэлтүүд   | Харьцаа   | 2020.12.31 | 2021.12.31 | Өмнөх онтой харьцуулахад |
|-----|---|---|------------|------------|--------------------------|
| 5.1 | Үндсэн хөрөнгийн хувийн жин   | Нийт ҮХ-н өртөг / Балансын цэвэр дүн  | 0.88       | 0.87       | -0.02                    |
| 5.2 | ҮХ-н нийт дунд үйлдвэрлэлийн зориулалттай үндсэн хөрөнгийн зэлэх хувийн жин | Үйлдвэрлэлийн зориулалттай ҮХ / Нийт ҮХ-н өртөг   | 0.84       | 0.83       | -0.01                    |
| 5.3 | Үндсэн хөрөнгийн элэгдлийн коэффициент                                      | ҮХ-н хур элэгдэл / ҮХ-н балансын өртөг  | 0.43       | 0.44       | 0.01                     |
| 5.4 | ҮХ-н шинэчлэлийн коэффициент  | Тайлант хугацаанд шинээр ашиглалтанд орсон ҮХ-н анхны өртөг / Тайлант хугацааны эцэст байсан ҮХ-н анхны өртөг | 0.00       | 0.00       | 0.00                     |
| 5.5 | ҮХ-н хасагдалтын коэффициент  | Тайлант хугацаанд ашиглалтаас хасагдсан ҮХ-н анхны өртөг / Тайлант хугацааны эцэст байсан ҮХ-н анхны өртөг    | 0.00       | 0.00       | 0.00                     |



### 6. Ашигт ажиллагааны шинжилгээ

|     | Үзүүлэлтүүд                                  | Харьцаа  | 2020.12.31 | 2021.12.31 | Өмнөх оной харьцуулалтад |
|-----|--|--|------------|------------|--------------------------|
| 6.1 | Борлуулалтын ашигт ажиллагаа                 | Үндсэн ажиллагааны цэвэр орлого / Борлуулалтын орлого    | 0.00       | -0.01      | -0.01                    |
| 6.2 | Өртгөөр тооцсон борлуулалтын ашигт ажиллагаа | Үндсэн ажиллагааны цэвэр орлого / Борлуулалтын бүт.өртөг | 0.00       | -0.01      | -0.01                    |
| 6.3 | Хөрөнгийн ашигт ажиллагаа                    | Цэвэр ашиг / Балансын цэвэр дүн                          | -0.03      | 0.02       | 0.05                     |
| 6.4 | Өөрийн капиталын ашигт ажиллагаа             | Цэвэр ашиг / Өөрийн капитал                              | -0.07      | 0.03       | 0.11                     |

### 7. Мөнгөн урсгалын шинжилгээ

|     | Үзүүлэлтүүд                            | Харьцаа  | 2020.12.31 | 2021.12.31 | Өмнөх оной харьцуулалтад |
|-----|--|--|------------|------------|--------------------------|
| 7.1 | Мөнгөн орлого ба борлуулалтын харьцаа  | Үйл ажиллагааны мөнгөн орлого / Борлуулалтын орлого              | 0.96       | 0.89       | -0.08                    |
| 7.2 | Мөнгөн орлого ба хөрөнгийн харьцаа     | Үйл ажиллагааны мөнгөн орлого / Балансын цэвэр дүн               | 0.26       | 0.26       | 0.00                     |
| 7.3 | Мөнгөн зарлага ба борлуулалтын харьцаа | Үйл ажиллагааны мөнгөн зарлага / Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 0.02       | 0.02       | 0.00                     |







## ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

- > ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААР
- > САНХҮҮГИЙН ДОТООД АУДИТ
- > ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО ISO9001:2016 СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР
- > ТАРИФЫН ЗОХИЦУУЛАЛТ
- > ЭРЧИМ ХҮЧНИЙ ЭХ ҮҮСВЭРҮҮДИЙН 2021 ОНЫ ҮНИЙН СУДАЛГАА





## ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААР

2021 онд станцын хэмжээний аваари, I, II зэргийн саатал, үйлдвэрлэлийн осол гараагүй.

ХАБЭАМС-ийн хүрээнд **279,517.1** мян төгрөгийн эх үүсвэртэй зардлын төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж гүйцэтгэлд нь хяналт тавин ажилласан.

2021 онд мэргэжлээс шалтгаалах өвчлөлийн эмнэлгийн үзлэг шинжилгээнд нийт **132** ажилтан хамрагдсан ба мэргэжлээс шалтгаалах өвчлөл тогтоогдоогүй байна.

2021 оны ажлын байрны нөхцлийг 2020 онтой харьцуулан үзвэл шуугиан **7.2** Дб-ээр буурч, чийглэг **3.9%** –аар өссөн ба стандартын шаардлагыг хангасан үзүүлэлттэй байна. 2021 онд орчны халууны хэмжээ буураагүй, харин өсөх хандлагатай байна.

ТДЦ-ийн ажлын байрны дундаж тоосролтыг **17.0** мг/м<sup>3</sup> болгох зорилт тавин ажилласан ба 2021 онд ажлын байрны дундаж тоосролт **17.2** мг/м<sup>3</sup> болсон. 2020 оны ажлын байрны дундаж тоосролттой харьцуулахад **0.6** мг/м<sup>3</sup>-р буурсан.

ЗЦ-ийн ажлын байрны тоосролтыг 10 мг/м<sup>3</sup> хүргэн бууруулах зорилт тавин ажилласан ба 2021 онд

ажлын байрны дундаж тоосролт **10.4** мг/м<sup>3</sup> болж өмнөх онтой харьцуулахад **0.3** мг/м<sup>3</sup> –аар буурсан.

2021 онд тоосролтыг бууруулж ажиллахын тулд **255** ажлыг 7 хоног, сар тус бүрээр төлөвлөн хийж, **100%** гүйцэтгэсэн байна.

Эрсдэлийг үнэлэх журмын дагуу 2011 оноос 2021 он хүртэл нийт **2962** ажил, ажилбарт үнэлгээ хийгдсэн байна. 2021 онд нийт **110** эрсдэлийн үнэлгээг шинээр хийж, **119** эрсдэлийн үнэлгээнд баяжилт хийсэн байна.

2021 онд **2450** аюул мэдээлэгдсэн ба тэдгээрээс **2236** аюулыг устгах арга хэмжээ авсан байна. Гүйцэтгэл **91.2%** –тай байна. Энэ нь **150** удаагийн эд хөрөнгийн хохирол гарах, **50** удаагийн эмнэлгийн анхны тусламж авах хэмжээний гэмтэл, **5** удаагийн хүний амь нас эрсдэх үр дагавартай аюултай тохиолдлоос сэргийлж чадсан гэж үзэхээр байна.

ISO45001:2018 стандарт руу шилжих ажлын хүрээнд агуулга зохицуулалтыг шинээр бий болгон, өмнө нь ашиглагдаж байсан журмуудыг сайжруулан боловсруулж байна.

### САНХҮҮГИЙН ДОТООД АУДИТ

#### Шилэн дансны мэдээлэлд хяналт тавих

Гүйцэтгэх захирлын 2020 оны 11-р сарын 03-ны өдрийн А/З31 тоот тушаалаар компанийн мэдээллийг шилэн дансанд оруулах алба, нэгж, хэлтэс, албан тушаалтнуудыг томилсон. Тушаалын дагуу хуулийн хугацаанд шилэн дансанд мэдээллүүдийг оруулах явцад хяналт тавин ажиллаж байна.

#### Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигийн боловсруулалт

НБББББ-ийг 2017 онд боловсруулж 2019 оноос эхлэн мөрдөн ажиллаж байгаа бөгөөд уг бодлогын баримт бичгийг дахин шинэчлэн боловсруулж, СТОУС-ын өөрчлөлтүүдийг салбарын онцлогт тохируулан бүртгэх зайлшгүй шаардлага тулгарсан тул 2021 онд шинэчилсэн.

#### Санхүүгийн бүртгэлийн ERP программ нэвтрүүлэлт

Санхүүгийн тайлангийн OD ERP программын 6.0 хувилбараас 10.0 хувилбарт амжилттай шилжиж,

2021 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг гаргасан. OD ERP 10.0 хувилбарт шилжих явцад гарсан алдаа зөрчлүүдийг тухай бүрт нь залруулж, санхүүгийн эрсдэл үүсэхээс сэргийлж ажилласан.

#### Санхүү бүртгэлд хяналт тавих

Санхүүгийн программ шинээр нэвтэрч байгаатай холбоотойгоор СБХ –ийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, аливаа алдаа зөрчлүүдийг тухай бүрт нь залруулан ажилласан.

#### Шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх ажил

"Мүүр-Аудит" ХХК нь 2020 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудитыг хийсэн бөгөөд 2 албан шаардлага, 5 зөвлөмжийг өгсөн. Дээрх зөвлөмж болон албан шаардлагын биелэлтэд хяналт тавин ажилласан биелэлт **100%**-тай байна. СБХ нь аудитын зөвлөмж болон албан шаардлагын биелэлтийг гаргаж, ТӨБЗГ, Үндэсний аудитын газруудад хүргүүлэн ажиллалаа.

## MNS ISO9001:2016 ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТ

**"ДЦС-4" ТӨХК-ийн ЧАНАРЫН БОДЛОГО:** Бид хүний хөгжлийг эрхэмлэж, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах чанарын менежментийн тогтолцооны үр

нөлөөг тасралтгүй сайжруулж, оновчтой горимоор хэрэглэгчийн сэтгэл ханамжид нийцсэн эрчим хүчээр найдвартай хангах.

"ДЦС-4" ТӨХК-ийн 2021 оны Чанарын зорилтын гүйцэтгэл

| №                       | Чанарын зорилт   | Дэвшүүлсэн зорилт  | Хувь  |
|-------------------------|------------------|--|-------|
| 1                       | Чанарын зорилт 1 | Нийт ажилтнуудын сэтгэл ханамжийн түвшинг 0.1-ээр дээшлүүлэх       | 66%   |
| 2                       | Чанарын зорилт 2 | Компанийн ажилтнуудын чадамжийн дундаж түвшинг 0.1-ээр дээшлүүлэх  | 100%  |
| 3                       | Чанарын зорилт 3 | "4S"-ийн түвшин хангасан ажлын байрны тоог 40%-д хүргэх            | 100%  |
| 4                       | Чанарын зорилт 4 | Байгууллагын эрсдэлийн түвшинг хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд хүргэх | 86.5% |
| 5                       | Чанарын зорилт 5 | Үндсэн тоноглогын тасралтгүй ажиллах дундаж цагийг 1080-д хүргэх   | 98.5% |
| 6                       | Чанарын зорилт 6 | Түлшний хувийн зарцуулалтыг 1430 ккал/кВтц хүргэх                  | 100%  |
| 7                       | Чанарын зорилт 7 | Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшинг 98%-д хүргэх                 | 100%  |
| Нийт зорилтын гүйцэтгэл |                  |  | 93%   |

### Сайн саналын системийн хөтөлбөрийн хэрэгжилт

2021 онд 822 санал цахим хэлбэрээр ирснээс сайн саналд тооцогдсон 746 саналд урамшуулал болгож 929,000 төгрөг зарцуулсан байна. Сайн саналын зөвлөл гаргасан санал бүрийг хэрхэн хэрэгжүүлэх, чанарын дугуйлантай хамтран ажиллах талаар бодлого барьж ажилласан. Ирүүлсэн саналуудыг ангилалаар нь авч үзэхэд компанийн хэмжээнд ХАБЭМС-ийн саналыг ажилтнууд түлхүү ирүүлэх хандлагатай байсан.

2021 онд Бүтээмжийн зөвлөлүүдийн үйл ажиллагааны хоорондын уялдаа холбоо сайжруулахын тулд дэмжигдсэн сайн саналыг чанарын дугуйлангаар дамжуулан хэрэгжүүлэх ажлыг амжилттай зохион байгуулж ажиллалаа.

### Ажлын байрны соёл "5s" хэрэгжилт, тасралтгүй сайжруулалт

2021 оны зорилтондоо Алба, хэлтэс, цех нэгжүүд 4S-ийн түвшин хангасан ажлын байрыг нэмэгдүүлж ажиллахаар зорилтоо батлуулж, ажлын байрны соёл "5S" хэрэгжилтийн урамшуулалд 1,700,000 төгрөг зарцуулсан. Бүтээмжийн хөтөлбөрийн хэрэгжилтийг тасралтгүй сайжруулж ажиллах ажлын хүрээнд шинэ ажилтны сургалт, ИТА-ууд цехийн ажилтнуудын мэдлэг боловсролыг дээшлүүлэх үүднээс гарын авлага болон мэдээллээр тогтмол хангаж ажиллалаа.

2021 оны чанарын зорилтонд "4S"-ийн түвшин хангасан ажлын байрны тоог 40%-д хүргэх зорилтыг дэвшүүлэн ажиллаж, "5S"-ийн зөвлөл чанарын зорилтын хүрээнд улирал бүр төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус "5S"-ийн цахим хурлыг зохион байгуулж ирсэн.

Компанийн хэмжээнд нийт 50 агуулах байгаагаас 1S-0, 2S-0, 3S-15, 4S-31, 5S-4 агуулах тус тус хангасан байна. Компанийн хэмжээнд нийт 766 ажлын байранд сар, улирал бүр Алба, хэлтэс, цех нэгж батлагдсан АШБ дагуу хуваарьт аудитаа зохион байгуулсан. Мөн "5S"-ийн хөтөлбөрийг дэмжсэн жишиг ажлын байрыг шалгаруулж, урамшуулсан.

"5S"-ийн дотоод аудитыг түүврийн аргаар зохион байгуулж, нэгж бүрийн 5S-ийн багууд өөрсдийн төлөвлөгөөний дагуу дотоод аудитаа хийж, тухай бүр санал зөвлөмж, сайжруулах санал гаргаж хамтран ажилласан.

### Чанарын дугуйлангийн хэрэгжилт

Компанийн хэмжээнд 117 Чанарын дугуйлан ажиллаж байгаагаас ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор хийсэн ажлаа дүгнүүлж шалгаруулалтыг эхний хагас жил болон сүүлийн хагас жилээр 2 удаа зохион байгуулсан. Чанарын дугуйлангийн хэрэгжилтийн III-р улирлын урамшуулалд 2,750,000 төгрөгийг зарцуулсан байна.



## ТАРИФЫН ЗОХИЦУУЛАЛТ

2021 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, өртөг зардал нэмэгдсэнтэй холбогдуулж 2020 онд мөрдөх үнэ тарифын саналыг боловсруулж өгсөн.

Үнэ тарифын саналыг ЭХЗХ-ны 2014 оны 231 дугаар тогтоолоор баталсан “Үнэ тариф тооцох аргачлал”-ын дагуу 2018, 2019 оны зардлын гүйцэтгэл, 2020 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, 2021 оны төсөл, Эрчим хүчний салбарын 2019–2020 оны хамт /тариф/-ын хэлэлцээрийг үндэслэн боловсруулж Эрчим хүчний зохицуулах хороонд 2021 оны 01 дүгээр сарын 19–нд 1/72 тоот албан бичгээр хүргүүлсэн.

2021 оны 01 дүгээр сарын 27–ны 35 тоот Эрчим хүчний зохицуулах хорооны тогтоолоор баталж 2021 оны 01 дүгээр сарын 01–нээс үнэ тарифт өөрчлөлт орж мөрдөж эхэлсэн.

2021.09.01–нд ЭХЗХ–нд 01/1181 тоот албан бичгээр хандан Зуух№1, 4–ийн экран хоолой солих **879.1** сая төгрөгийг ЭХЗХ–ны 2021.09.16–ны 432 тоот

тогтоолоор, 2021.10.13–14–нд ЭХЗХ–нд 01/1308, 01/1315 тоот албан бичгүүдээр хандан Зуух№4–ийн экран хоолойн засварт болон өр төлбөрийг бууруулах арга хэмжээг авч банкны богино хугацаат зээл авсны хүүгийн зардалд **1,664.9** сая төгрөгийг 2021.10.27–ны 481 тоот тогтоолоор шийдвэрлүүлсэн.

ЭХЗХ–ноос үнэ тариф батлахдаа Борлуулалтын орлогын шаардах хэмжээ /БОШХ/ буюу үйл ажиллагааны зардлыг **276,699.2** сая төгрөгөөр баталж, 2020 оны батлагдсан БОШХ–ээс **12,150.9** сая төгрөгөөр, компанийн өгсөн саналаас **38,585.4** сая төгрөгөөр, Үнэ тарифын бодит дүнгээс **18,987.0** сая төгрөгөөр тус тус бууруулсан. 2021 оны 12 дугаар сард үнэ тарифыг НХАЗ–т бий болсон зэрэг үр дүнг нийт ТЗЗ–чдэд тэгш хуваарилах тооцооны хүрээнд тус компанийн оны эхэнд **6.42%**-иар бууруулсан БОШХ–ний **5.56%** буюу **16,431.5** сая төгрөгийг буцаан тарифт тусгаж баталсан.

2021 онд мөрдөж ажилласан тарифууд

| №   | Тарифын ангилал               | Хэмжих нэгж | Тариф<br>2021.01.01 | Тариф<br>2021.09.01–12.31 | Тариф<br>2021.10.01–12.31 | Тариф<br>2021.12.01–12.31 |
|-----|-------------------------------|-------------|---------------------|---------------------------|---------------------------|---------------------------|
| 1   | Цахилгааны эрчим хүчний тариф | төг/кВтц    | 60.91               | 61.16                     | 62.36                     | 65.82                     |
| 1.1 | Энергийн тариф                | төг/кВтц    | 37.68               |                           |                           |                           |
|     | Чадлын тариф                  | м.төг/сар   | 8,393,132           |                           |                           |                           |
| 1.2 | /1–р улирал/                  | м.төг/сар   | 5,427,735           |                           |                           |                           |
|     | /2–р улирал/                  | м.төг/сар   | 5,427,735           | 5,485,277                 |                           |                           |
|     | /3–р улирал/                  | м.төг/сар   | 8,393,132           | 8,666,992                 | 10,097,029                | 21,972,086                |
|     | /4–р улирал/                  | м.төг/сар   | 8,393,132           | 8,666,992                 | 10,097,029                | 21,972,086                |
| 2   | Дулааны эрчим хүчний тариф    |             | 11,390.00           | 11,390.00                 | 10,710.00                 | 11,104.00                 |
| 2.1 | 1–р улиралд                   | төг/Гкал    | 12,003.56           |                           |                           |                           |
| 2.2 | 2–р улиралд                   | төг/Гкал    | 14,117.89           |                           |                           |                           |
| 2.3 | 3–р улиралд                   | төг/Гкал    | 4,911.12            |                           |                           |                           |
| 2.4 | 4–р улиралд                   | төг/Гкал    | 11,848.64           |                           | 9,952.02                  | 12,480.85                 |

Хэрэглэгчийг шууд хангах тарифууд

Хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчний үнэ тариф **140.59** төг/кВтц, сэргээгдэх эрчим хүчийг дэмжих

тариф **23.79** төг/кВтц–аар тогтвортой мөрдөгдсөн. 2019 оны 7 дугаар сараас хойш өөрчлөлт ороогүй болно.

## ЭРЧИМ ХҮЧНИЙ ЭХ ҮҮСВЭРҮҮДИЙН 2021 ОНЫ ҮНИЙН СУДАЛГАА

| №  | Эх үүсвэрүүд                          | 2021 он дундаж тариф, төг/<br>кВтц |
|----|---------------------------------------|------------------------------------|
| 1  | ДУЛААНЫ IV ЦАХИЛГААН СТАНЦ            | 62.92                              |
| 2  | ДУЛААН III ЦАХИЛГААН СТАНЦ            | 104.39                             |
| 3  | ДУЛААН II ЦАХИЛГААН СТАНЦ             | 165.76                             |
| 4  | ДАРХАНЫ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ       | 166.20                             |
| 5  | ЭРДЭНЭТИЙН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ    | 165.79                             |
| 6  | УХАА-ХУДАГ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ    | 191.44                             |
| 7  | ДАЛАНЗАДГАДЫН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ | 134.96                             |
| 8  | ГОК ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ           | 140.92                             |
| 9  | ИМПОРТ                                | 250.09                             |
| 10 | САЛХИН ЦАХИЛГААН СТАНЦ                | 268.98                             |
| 11 | НАРНЫ ЦАХИЛГААН СТАНЦ                 | 447.51                             |



# ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАГНАЛ



## ХҮНИЙ НӨӨЦ

2021 онд дансны тоогоор нийт 1480 ажилтантай ажиллалаа. Нийт ажилтнуудын 830 ажилтан буюу 56.1% нь дээд, 170 буюу 11.5% нь тусгай дунд, 480 ажилтан буюу 32.4% нь бүрэн дунд боловсролтой байна.


Нийт ажилтнуудын 363 ажилтан буюу 24.3%-ийг эмэгтэйчүүд эзэлж байна.

## Ажилтнуудын насны ангилал:

- 18–25 насны – 96 ажилтан
- 26–35 насны – 447 ажилтан
- 36–50 насны – 712 ажилтан
- 51–60 насны – 237 ажилтан
- 60–аас дээш насны – 4 ажилтан

## Ажилтнуудын ажилласан жил:

- 0–5 жил – 403 ажилтан
- 6–10 жил – 256 ажилтан
- 11–15 жил – 260 ажилтан
- 16–20 жил – 225 ажилтан
- 21–ээс дээш жил – 352 ажилтан



2021 онд компанийн ажиллагсдын мөрдөх “Ёс зүйн дүрэм”-ийг шинэчлэн баталж, “Ёс зүйн зөвлөл”-ийг байгуулан ажиллаж байна.

## Мэдээллийн систем

Компанийн үйл ажиллагааны мэдээллийг бүх ажилчдад ил тод, үнэн зөв, шуурхай хүргэх зорилгоор мэдээллийн цогц системийг тогтмол ажиллуулж байна. Үүнд:

- Дотоод сүлжээ буюу Inbit мессенжер
- Мэдээлэл түгээх дэлгэцүүд
- Компанийн цахим хуудас
- Компанийн facebook page, group
- Телеграм мессенжер

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдах авах тухай хууль болон Засгийн газрын 2021 оны 12-р сарын 17-ны өдрийн өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2021 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх хуулийн дагуу 2021 оны 1-р сарын 10-ны дотор худалдан авахын ажиллагааны төлөвлөгөө, 1-р сарын 15-ны дотор тайланг хүргүүлсэн.

## ИЛ ТОД, ЁС ЗҮЙН БАЙДАЛ

Аливаа арга хэмжээ, үйл явдлын мэдээллийг цаг хугацаанд нь зураг, бичлэгтэйгээр боловсруулан компанийн цахим хуудсанд 25 гаруй мэдээллийг оруулсан ба энэхүү үйл ажиллагаануудын баримт файлууд нийт 21 хавтас /26 GB орчим/ болон архивлагдсан.

УОК-оос гаргасан Дэлхий нийтэд тархсан цар тахал COVID-19-өөс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээлэл, зөвлөмжийг тухай бүр авч боловсруулан компанийн мэдээллийн доорхи сувгуудаар ажилтнуудад сурталчилан ажилласан.

- [www.tpp4.mn](http://www.tpp4.mn)
- [www.facebook.com/thermalpowerplant4/](https://www.facebook.com/thermalpowerplant4/)
- [www.facebook.com/groups/ThermalPowerPlant4/](https://www.facebook.com/groups/ThermalPowerPlant4/)

## ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

2021 онд 42,7 тэрбум төгрөгийн төлөвлөснөөс 39,25 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэйгээр ажилласан. Тендер шалгаруулалтыг дараах байдлаар зохион байгууллаа. Нээлттэй тендер шалгаруулалтаар 80%, харьцуулалтын худалдан авалтаар 10%, шууд гэрээ байгуулах 1%, шууд худалдан авалт 0.3%-ийг тус тус эзэлж байна. Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих хүрээнд 25 компанитай 2.39 тэрбум төгрөгийн гэрээ хийн ажиллалаа.



## БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР

Байгаль орчныг хамгаалах чиглэлээр нийт 21 ажил төлөвлөснөөс 95%-ийн гүйцэтгэлтэй гарсан байна.

### Агаарын бохирдлоос сэргийлэх ажлын талаар

Сар бүр ажиллагаанд байсан зуухнуудын утааны хийн найрлага дахь хорт бодисын хэмжилтийг үндэслэн массын болон эзлэхүүний агууламжийг тодорхойлсон. Хорт бодисуудын агууламжийг MNS 5919:2008 стандарттай харьцуулахад, нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), азотын исэл (NO<sub>x</sub>), хүхрийн исэл (SO<sub>x</sub>), дэгдэмхий үнсний хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрээгүй байна.

Зуухны утааны хийтэй агаарт хаягдаж байгаа NO<sub>x</sub>, SO<sub>2</sub>, CO, CO<sub>2</sub>, O<sub>2</sub>-ийн хэмжээг утааны хийн анализатор ENDA-5800, дэгдэмхий үнсний хэмжээг DDM-1c тоосонцорын агууламж хэмжигчээр хэмжсэн хэмжилтийн үр дүн Улаанбаатар хотын агаарын чанарын cems.adaag.mn сайт дээр 24 цагаар тасралтгүй мэдээлэгдсэн.

Хэмжилтийн үр дүнг "РД 34.02.305-98 ДЦС -ын зуухны агаар мандалд хаях бохирдуулагч бодисын хэмжээг тодорхойлох аргачлал" -ын дагуу тодорхойлож, БОАЖЯ болон ЦУОШГ-т цахим хэлбэрээр мэдээлж байна.

### Үнсийг ашиглах талаар

2021 онд хуурай үнсэнд цацрагийн шинжилгээ хийлгэн Улсын байцаагчийн дүгнэлт гаргуулсны үндсэн дээр хүсэлт гаргасан 29 компанид 55346 тн үнсийг борлуулсан байна.

### Ногоон байгууламжийн талаар

2021 онд ногоон байгууламжид 36,1 сая төгрөг төлөвлөн хэрэгжүүлж ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн. Үүнд:

Хаврын тарилтаар хайлаас 1125 ширхэг, гацуур 18 ширхэг, шар хуайс 1950 ширхэг, агч мод 95 ширхэг, бутлаг ургамал 270 ширхэг тарьсан.

Нийтдээ 286 м<sup>2</sup> талбайн хог чулууг зайлуулж, 398 м<sup>2</sup> талбайг зүлэгжүүлсэн.

### Хөрс, усны бохирдлыг бууруулах талаар хийсэн ажил

#### Хяналтын худагны шинжилгээ:

Хяналтын худаг №1, 2 болон гүний худгийн усны шинжилгээг сар бүр Хими цехийн лабораторид хийлгүүлэн, хяналт тавьсан. Монгол Улсын "Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ", MNS 900:2018 стандартын шаардлагыг бүрэн хангаж байна.



#### Хөрсний шинжилгээ:

Станцын хашаан дотроос хөрсний 3 дээж, үнсэн сан орчмоос 2 дээж, нүүрснээс 2 дээж авч шинжилгээнд хамруулсан нь стандартын шаардлагыг хангаж байна.

#### Химийн бодис халгалалт, хамгаалалт

2021 онд химийн хорт сав баглаа боодлыг устгах, дахин боловсруулах талаар "Цэцүүх" ХХК -тай хамтран ажиллах гэрээ байгуулан канистр-489, бочек-15, шүлтийн уут-490, давсны шуудай-2500 ширхэгийг буцаан хүлээлгэж өгсөн.

#### Хог хаягдлын тухай:

- Эмнэлгийн хог хаягдлыг "Элемент" ХХК -тай гэрээ байгуулан 7 хоногт 2 удаа ачуулсан.
- Улаанбаатар хотын төвлөрсөн хогийн цэгт 334.9 тн ахуйн хог хаягдлыг хаясан.
- Үнсэн санд 229,751.8 тн үнс, 14,168.52 тн шлагыг хаясан.

#### Цацраг идэвхийн шинжилгээ:

2021 онд үнсэн сан, нүүрс, хөрснөөс дээж авч, МХЕГ-ын цацрагийн лабораторид цацраг идэвхт изотопуудын хувийн идэвх тодорхойлох шинжилгээнд хамруулсан. Зөвшөөрөгдөх хэмжээнд байна.





## НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

- > НИЙГМИЙН АСУУДАЛД ЧИГЛЭСЭН АЖЛУУД
- > ХОР СААРМАГЖУУЛАХ БҮТЭЭГДЭХҮҮН ТҮГЭЭЛТ
- > СОЁЛ УРЛАГ, ОЛОН НИЙТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР





## НИЙГМИЙН АСУУДАЛД ЧИГЛЭСЭН АЖЛУУД

2021 онд **246** хүнд **2,165.0** сая төгрөгийн буцалтгүй тусламж, тэтгэмж, урамшуулал, нөхөн төлбөр олгосон байна.

2021 онд “ДЦС-4” ТӨХК-ийн ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд тус компанид олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа **60** ажилтанд орон сууцны асуудлаа шийдвэрлэхэд тус бүрт нь арван сая төгрөгийн дэмжлэгийг олгосон.

Компанийн захиргаанаас үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдаж групп тогтоогдсон ажилтнууддаа хүндэтгэл үзүүлэн **54** иргэнд **3,240.000** төгрөгийн буцалтгүй тусламж, мөн **1** ажилтанд хорт


хавдар, хүнд хэлбэрийн мэс засалд ороход нь дэмжлэг болгон **5,000.000** төгрөг, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтөөр орон тоо нь цомхотгодсон **1** ажилтанд **11,977.068** төгрөг, эрүүл мэндийн хувьд гүйцэтгэж байгаа ажил, албан тушаалдаа тэнцэхгүй болсон нь ХЧАХТогтоох актаар тогтоогдсон **2** ажилтанд **17,660.337** төгрөгийн тэтгэмжийг тус тус олгосон байна.

Компанийн ажилчдад зориулсан сувилал байгуулах ажлын хүрээнд мэргэжлийн байгууллагаар зураг төсөв хийлгэхээр гэрээ байгуулан ажиллаж байна.

### Нийгмийн халамжид хамрагдсан хүний тоо, зардал /сая.төг/

|      |     |            |
|------|-----|------------|
| 2017 | 252 | 964.3 ₮    |
| 2018 | 278 | 1,388.37 ₮ |
| 2019 | 406 | 1,921.02 ₮ |
| 2020 | 370 | 2,532.34 ₮ |
| 2021 | 246 | 2,165.02 ₮ |

### Нийгмийн халамжийн зардлын бүтэц



2021 онд “Хор саармагжуулах хүнсний шингэн бүтээгдэхүүн олгох тухай” 2016 оны А/149 тоот тушаалын

### ХОР СААРМАГЖУУЛАХ БҮТЭЭГДЭХҮҮН ТҮГЭЭЛТ

дагуу нийт **89,196,600.00** төгрөгийн үнэ бүхий **148,661** ширхэг сүүг станцын ажилчдад түгээсэн байна.

### СОЁЛ, СПОРТ, ОЛОН НИЙТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахалтай холбоотойгоор олон нийтийг хамарсан үйл ажиллагаа зохиогдоогүй бөгөөд 11-р сарын 1-нээс 50%-ийн дүүргэлттэй олон нийтийн үйл ажиллагааг нээснээр компанийн тэмцэн уралдаан болон уулзалт сургалт зөвлөгөөний үйл ажиллагаа нээгдсэн юм.

- Хурал, зөвлөгөөн:
- Байгууллагын алба хэлтэс, цех, нэгжүүдийн соёл урлаг, олон нийтийн ажлуудад хурлын заал танхим тайз дэлгэц, техник хэрэгсэл, апаратураар байнга үйлчлэн бэлэн байдлыг хангаж ажилласан ба Дөл танхимд **100** удаагийн үйл ажиллагааны явцад давхардсан тоогоор **4030** хүн үйлчлүүлсэн байна.



**Спортын уралдаан тэмцээн:****Волейбол**

2021 оны төлөвлөгөөнд тусгагдсан компанийн нийт ажиллагсдын дунд 7 төрөлт тэмцээн 85%-ийн гүйцэтгэлтэй буюу 6 төрөлт тэмцээнийг амжилттай зохион байгууллаа. Компанийн дэргэдэх "Эрчим" волейболын эрэгтэй баг тамирчид 2021 оны MBX-ны "Үндэсний дээд лиг"-ийн тэмцээнд амжилттай оролцож хүрэл медалийн болзол хангаснаар 2019, 2021 оны хошой хүрэл медальтан болсон. Мөн тэмцээний "Шилдэг хаагч"-аар багийн довтлогч СдМ Б.Батсуурь шалгарлаа.



Польш улсын Варшав хотноо зохион байгуулагдсан Мастеруудын Дэлхийн аварга шалгаруулах 11 дэх удаагийн "Каман цом-2021" тэмцээний +40 ангилалд Ази тив болон Монгол улсаа төлөөлөн СТ.НБТХМэргэжилтэн ОУХМ Т.Отгонтөгс амжилттай оролцон дэд байр мөнгөн медаль хүртэв.

MIZUNO брендийн Монгол дахь албан ёсны борлуулагч "Хос гангийн оргил" ХХК-аас зохион байгуулсан топ-4 багийн дунд өндөр шагналын сантай тэмцээн болж "Эрчим" баг "Натур Мед Ноён" багийн эсрэг тоглож 3:1 харьцаагаар хожиж тоглолтын тэргүүлээ.

**Хөлбөмбөг**

"HISENSE" үндэсний дээд лигийн тэмцээн амжилттай болж өндөрлөв. Эрчим клубын баг тамирчдын хувьд лигийн хүснэгтийн 5-р байраар өндөрлөж сүүлийн 2 жилийн хугацаанд медалийн буухай нь тасраад байгаа бол тэдний залгамж халаа болсон залуучууд нь 2-р лигийн тэмцээнээс мөнгөн медаль хүртэж дараа жил дээд лигт хүч сорих болзлоо хангасан юм.

Залуучуудын цомын тэмцээнд Эрчим клуб хэсэгтээ хожигдолгүй гарч ирэх хасагдах шатанд харамсалтайгаар хожигдсоноор тэмцээнээ өндөрлүүлээ.

Мастерсын улсын аварга шалгаруулах тэмцээнд ахмадын баг тамирчид 35+, 50+, 55+ ангилалуудад аваргалж 3 алтан медаль хүртсэн бол 45+ ангилалд хүрэл медаль хүртэв.



**"Дулааны IV Цахилгаан Станц" ТӨХК**

18080 Баянгол дүүрэг, 20-р хороо, Эрчим хүчний гудамж

Факс: (976)-7028-1819 Утас: 7000-1284

Вэб хаяг: <http://www.tpp4.mn>

Эл.шуудан: [info@tpp4.mn](mailto:info@tpp4.mn)